

Сумын ИТХ-аас 2012-2017 онд хийсэн ажил**2013 он**


1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 25-р тогтоолоор АМГ-ын даргын дүгнэлтийг үндэслэн **“Ембүү толгой”**, **“Шарангад”** нэртэй газруудыг бичил уурхайн зориулалтаар сумын тусгай хэрэгцээнд авч жонш олборлох зөвшөөрөл гаргасан. Тус газарт 5 нөхөрлөл ажиллаж иргэд өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжтой болсон.



2. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 29-р тогтоолоор ИТХ-ын дэргэд **“Иргэний танхим”** байгуулж, **“Иргэний танхимын ажиллах журам”**-ыг баталсан. Иргэний танхимаас уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүд, сумын ЗДТГ, иргэд, ТББ-ууд зэрэг гурван талын оролцоот **“Олборлох үйлдвэрлэлийн ил, тод байдлын хэлэлцүүлэг-өдөрлөг”** сэдэвт хэлэлцүүлгийг жил бүрийн 3-р сарын 25-30-ны хооронд тогтмол зохион байгуулж байна.



3. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 31-р тогтоолоор МУЗГ-аас тус суманд хэрэгжүүлсэн “Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд сумын төвийн усан хангамж, цэвэрлэх байгууламж, төвлөрсөн халаалтын зургийн даалгавар боловсруулах 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилж тус ажлын хэсэг нь цэвэр, бохир усны шугам, төвлөрсөн халаалтын шугам тавих газар, төвлөрсөн уурын зуух, бохир ус цэвэрлэх байгууламжийн байршлын газрыг сонгож, төвийн ААН, байгууллага, айл өрхийн байшингуудын эзэлхүүн, цахилгааны шугам сүлжээний зураглал зэргийг гаргаж төслийн зургийн даалгаврын судалгааг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өглөө.



2014 он

4. 2014 онд ИТХ-аар сумын сүлд, тугийг шинэчлэн батлах, орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх, сумын төвийг хөгжүүлэх, бэлчээр хамгаалах, иргэдийн оролцоог хангах чиглэлээр бодлого боловсруулан батлаж хэрэгжүүллээ. Тухайлбал: Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамжийн хэмжээг нэмэгдүүлсэн, газрын төлбөрийг

ангилаан ялгаж ялгавартай тогтоосон, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн шугам сүлжээний байршлын зураглалыг баталсан, Зарим уулыг сумын тахилгатай болгосон, сумын нийгэм, эдийн засгийн 2009-2020 оны төлөвлөгөөнд үнэлгээ хийж шинэчилсэн, сумын бодлого, төлөвлөлт, хяналтын зөвлөлийг шинэчлэн баталсан зэрэг нь сумаа хөгжүүлэх, ОНХС, СХС, ХЭДС-ийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад ач холбогдолтой болсон. Зураг № 4,5,6,7,8,9,10



Сумын нийгэм, эдийн засгийн 2014-2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд оруулах төслүүдийг эрэмбэлж байгаа нь


Сумын бодлого, төлөвлөлт, хяналтын зөвлөлийн чиг үүргийн бүтэц, сангуудын уялдаа, холбооны бүтцийн схем гаргаж байгаа нь

Жил бүр шинэ үндсэн хууль баталсаны ойгоор иргэний андгай өргүүлэх, шатрын болон үндсэн хуулийн сэдэвт төрөл бүрийн тэмцээн явуулдаг.



2015 он

2015 онд ИТХ-аар орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, сумын төвийн дэд бүтцийн ажлыг чанартай хийж дуусгах, газар нутаг, бэлчээрээ уул уурхайн эвдрэл, гэмтлээс хамгаалах, иргэдийн оролцоог хангах, саналыг авах чиглэлээр ажиллаж, бодлого боловсруулан батлаж хэрэгжүүллээ.



Орон нутгийн тусгай хамгаалалтанд 6 байршилд нийт **919271,67** га газрыг авсан нь сумын нийт нутаг дэвсгэрийн **59.6** хувийг эзэлж байна. Энэ нь нутаг дэвсгэрийнхээ нөөц баялагийг илрүүлж ирээдүйд ашиглах нөхцлийг эсэргүүцэж байгаа биш бөгөөд замбараагүй лиценз олголт, дээж авах нэрийдлээр ашигт малтмал олборлох явдлаас урьдчилан

сэргийлж, даац хэтэрсэн бэлчээрээ хамгаалах арга хэмжээ юм. Зураг №11

Иргэний танхимаас уламжлалын дагуу уул уурхайн сэдэвт 3 талт хэлэлцүүлэгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн онцлог нь хэлэлцүүлэгт аймгийн ЗДТГ, УБ хотын 7 ТББ, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан сумдын төлөөлөл, удирдлагууд оролцож цар хүрээгээ тэлж, ач холбогдол өндөр байлаа. Зураг №12



Жил бүр ИТХ-ын Тэргүүлэгчдээс мэдээлэл сэтгүүл гарган төлөөлөгчид, албан байгууллагын дарга нарт хүргүүлдэг. Зураг №13

2016 он.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 04-р сарын 28-ны өдрийн хуралдаанаар Сумын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг иргэд, ТББ-ын төлөөлөлийг оролцуулан 16 хүний бүрэлдхүүнтэй байгууллаа. Ажлын хэсэг “Хил хязгааргүй алхам”ТББ-тай хамтран 2 өдрийн сургалт зохион байгуулж БОМТөлөвлөгөөний төслийг боловсруулав. Сургалтанд Хулд,Луус сумын төлөөлөл оролцлоо. БОМТөлөвлөгөөний төслийг Хулд,Луус сумдад болон” Хил хязгааргүй алхам”ТББ-д хүргүүлэн санал авч сайжруулан ИТХ-аар хэлэлцүүлнэ. . БОМТ боловсруулж хэрэгжүүлсний үр дүнд сумын байгалийн бүх төрлийн нөөц баялагийн судалгаа гаргаж үнэлэх, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, бэлчээрийг усжуулах, ногоон байгууламж буй болгох, байгалд ээлтэй үйлдвэрлэл явуулах,иргэд, өсвөр үеийхэнд экологийн боловсрол олгох, цөлжилтийг сааруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зэргээр тогтвортой хөгжиж, иргэд эрүүл аюулгүй орчинд, ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. Зураг№14,15,16



2017 он

“Уул уурхай дахь ИТХ-ын хяналт” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу нийт төлөөлөгчид, БИНХ-ын дарга нар, БЗД нар, иргэдийн төлөөллийг оролцуулан ашиглалтын лицензтэй 3 ААН, Хайгуулын лицензтэй 6 аж ахуйн нэгжид хяналт үнэлгээ хийж хяналтын картыг туршиж үзлээ. Хяналтын үр дүнг Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж **“Сумын нутаг дэвсгэрт геологи, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тавих хяналт, үнэлгээний журам”-ыг хяналтын картын загварын хамт батлуулав. Зураг№17**



Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч хөгжсөний 25 жилийн ойг тусгай хөтөлбөрөөр тэмдэглэж ширээний теннис, “АХА” тэмцээн зохион байгуулж урлагийн тоглолт үзүүллээ. Ойн хурал дээр үе үеийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар түүхэн дурсамжаа ярьж зөвлөгөө өглөө.